



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 612

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2018 он болон 2019 оны 3 дугаар улирлын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчин 6.8 сая төгрөгийн зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 тоот дугаартай хуралдааны тэмдэглэлийг зөрчин эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, сонгон шалгаруулалтгүйгээр байр, талбай түрээслэн ашигласан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11, 8 дугаар зүйлийн 8.4, 44 дүгээр зүйлийн 2, Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг зөрчин 693.1 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж явуулсан зэрэг нийт 699.9 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөлд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчил дутагдал гаргасан, хяналт тавих чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн ажилтан, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хариуцлага тооцож шаардлагатай арга хэмжээ авах;

2.2. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн биржийн тухай хууль, Гаалийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, уялдаа холбоог сайжруулах талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

3. “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Х.Баатарт дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2. Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахыг таслан зогсоох;

000133

3.3. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлахдаа орон тоо, бүтцийг үйл ажиллагааны чиглэлтэй, ажиллагсдын цалин хөлсийг компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлттэй уялдуулан тогтоох;

3.4. Иргэд байгууллагатай хийсэн гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн үндэслэлийг сайжруулж, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах, гэрээ байгуулах, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангах, дүгнэх ажлыг хууль журамд нийцүүлэх;

3.5. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлан ажиллах;

3.6. Компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг хууль журамд нийцүүлэн зохион байгуулах;

3.7. Нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомж, НББОУС, Сангийн яамнаас баталсан журмын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангуулах, зөвшөөрсөн программ хангамж ашиглах ажлыг зохион байгуулах;

3.8. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ үндсэн болон бусад хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, элэгдэл, хорогдлын шимтгэл тооцох хугацаа, аргачлалын талаар тусгаж мөрдөн ажиллах;

3.9. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн  
612 дугаар тогтоолын хавсралт



“Хөдөө аж, ахуйн бирж” ТӨХХК-д хийсэн  
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг  
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Бусдаас байр, талбай түрээслэхдээ зохих зөвшөөрөл аваагүй.	2018-2019 он	-	ТӨБЗГ-ын 2018 оны 01 тоот хуралдааны тэмдэглэл	ТӨБЗГ-аас зохих зөвшөөрлийг авах.
2	Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчин зохион байгуулсан	2019 он	693.11	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11, 8 дугаар зүйлийн 8.4, 44 дугаар зүйлийн 44.2, Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолын холбогдох заалт	Худалдан авах ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулах
3	2018, 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн	2018-2019 он	6.80	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах
<b>НИЙТ ДҮН:</b>			<b>699.9</b>		